



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Сайхан сумын гуравдугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2025/220/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn Сүхбаатар сум 2025 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 70363040 Цахим хаяг: enkhuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Аудитын гүйцэтгэсэн: Мэдээлэл Аудит ХХК-ийн Сэлэнгэ салбар Утас: 99499667 Цахим хаяг: infoauditselenge@gmail.com</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Аудитын дүгнэлт.....	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5-9
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	10
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	10
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....	11
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12-13
4. Аудитын тайлан.....	14
4.1 Ерөнхий зүйл	14
4.2 Материаллаг байдал	15
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
5. Аудитын илрүүлэлт	17
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
БШУГ	Боловсрол, шинжлэх ухааны газар
ЗГ	Засгийн газар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

**САЙХАН СУМЫН
ГУРАВДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Г.ҮҮРЦАЙХ ТАНАА**

2025.02.25 № СЭА-2025/220/НА-СТА-ТШЗ

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Сайхан сумын гуравдугаар цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Сайхан сумын гуравдугаар цэцэрлэг нь Боловсролын ерөнхий газрын даргын 2024 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн А/355 дугаар тушаалаар сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгээр 2 дугаар түвшинд үнэлэгдэж урамшуулалд 27,151.7 мянган төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Дээд шатны төсвийн захирагчаас тус цэцэрлэгийн тайлант оны төсвийн төлөвлөлт, хуваарилалтыг тухайн сарын гүйцэтгэлд үндэслэн тайлант онд нийт 7 удаа өөрчилж, зохицуулалт хийж байгаа буюу бодит гүйцэтгэлтэй уялдуулан өөрчилж байгаа нь төсвийн төлөвлөлтийг тооцоо, судалгаанд үндэслэн бодитоор төлөвлөдөггүй болохыг харуулж байна.

Байгууллагын төсөв, санхүүжилтийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Тус цэцэрлэг нь 2024 оны “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”-нд тусгагдсан 5 зорилтын хүрээнд 35 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж 93.6 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	201,343,128.00	222,572,607.28
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	137,769,101.06	136,735,707.60
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	137,769,101.06	136,735,707.60
3121	Төгрөг	137,769,101.06	136,735,707.60
31211	Төрийн сангийн харилцах	137,769,101.06	136,735,707.60
35	БАРАА МАТЕРИАЛ	63,574,026.94	85,836,899.68
354	Хангамжийн материал	63,574,026.94	85,836,899.68
3547	Бусад хангамжийн материал	63,574,026.94	85,836,899.68
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	349,584,376.65	318,493,942.50
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	349,584,376.65	318,493,942.50
392	Биет хөрөнгө	328,102,051.80	297,089,742.50
39201	Барилга, байгууламж, орон сууц	503,710,170.02	503,710,170.02
39202	Хуримтлагдсан элэгдэл	(204,359,414.36)	(237,620,609.36)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	51,871,172.00	62,824,072.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(35,449,212.10)	(41,696,233.23)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	25,368,052.14	25,877,952.14
39208	Хуримтлагдсан элэгдэл	(17,482,207.90)	(19,921,700.11)
39214	Бусад үндсэн хөрөнгө	5,956,845.58	5,956,845.58
39215	Хуримтлагдсан элэгдэл	(3,829,444.52)	(4,356,845.48)
39217	Ном	2,316,090.94	2,316,090.94
393	Биет бус хөрөнгө	21,482,324.85	21,404,200.00
39301	Програм хангамж	1,250,000.00	1,250,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,171,875.15)	(1,250,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	21,404,200.00	21,404,200.00
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	550,927,504.65	541,066,549.78
IV	НИЙТ ӨР ТӨЛБӨР	14,979,836.22	8,154,693.75
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	14,979,836.22	8,154,693.75
413	Өглөг	14,979,836.22	8,154,693.75
4132	Бараа үйлчилгээний зардлын өглөг	14,979,836.22	8,154,693.75
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	535,947,668.43	532,911,856.03
51	Засгийн газрын хувь оролцоо	535,947,668.43	532,911,856.03
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	533,912,670.00	533,912,670.00
51101	Өмч: - төрийн	533,912,670.00	533,912,670.00
512	Хуримтлагдсан үр дүн	(431,264,311.90)	(434,300,124.30)
5121	Өмнөх үеийн үр дүн	(431,264,311.90)	(431,264,311.90)
5122	Тайлант үеийн үр дүн		(3,035,812.40)
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	433,299,310.33	433,299,310.33
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	550,927,504.65	541,066,549.78

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,144,777,400.00	1,325,470,599.94
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	26,190,200.00	50,226,399.94
120	Нийтлэг татварын бус орлого	26,190,200.00	50,226,399.94
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	70,000.00	35,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	70,000.00	35,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	2,497,000.00	10,353,000.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	23,623,200.00	39,838,399.94
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,118,587,200.00	1,275,244,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	864,345,800.00	1,032,397,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	864,345,800.00	1,032,397,400.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	254,241,400.00	242,846,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	254,241,400.00	242,846,800.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,026,264,537.58	1,328,506,412.34
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,026,264,537.58	1,328,506,412.34
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,026,264,537.58	1,310,857,712.34
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	571,689,057.21	785,621,238.66
210101	Үндсэн цалин	394,656,290.21	492,545,015.15
210102	Нэмэгдэл	160,405,286.00	275,140,873.51
210104	Урамшуулал	16,627,481.00	17,935,350.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	72,683,824.00	98,963,984.80
210201	Тэтгэврийн даатгал	48,728,498.00	68,068,844.35
210202	Тэтгэмжийн даатгал	6,253,981.00	8,024,451.78
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,999,765.00	3,942,925.89
210204	Ажилгүйдлийн даатгал	1,252,333.00	3,941,231.89
210205	Эрүүл мэндийн даатгал	12,449,247.00	14,986,530.89
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	209,376,535.33	232,551,657.53
210301	Гэрэл, цахилгаан	10,419,715.80	10,228,212.42
210302	Түлш, халаалт	187,363,963.53	211,842,469.11
210303	Цэвэр, бохир ус	11,592,856.00	10,480,976.00
2104	Хангамж, бараа материалын зардал		3,066,327.20
210408	Бараа материал акталсны зардал		3,066,327.20
2105	Нормативт зардал	75,539,130.00	91,595,250.00
210502	Хоол, хүнс	75,539,130.00	91,595,250.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,970,500.00	3,470,000.00
210604	Урсгал засвар	5,970,500.00	3,470,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,418,600.00	2,797,400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,418,600.00	2,797,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	89,586,891.04	92,791,854.15
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	39,711,422.73	41,414,320.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,255,800.00	8,824,300.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	45,619,668.31	42,553,234.15
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		17,648,700.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		17,648,700.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		17,648,700.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	118,512,862.42	(3,035,812.40)
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)		
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	118,512,862.42	(3,035,812.40)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,118,657,200.00	1,275,279,200.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	70,000.00	35,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	70,000.00	35,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	70,000.00	35,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	70,000.00	35,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,118,587,200.00	1,275,244,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	864,345,800.00	1,032,397,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	864,345,800.00	1,032,397,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	254,241,400.00	242,846,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	254,241,400.00	242,846,800.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	994,442,921.94	1,275,202,793.46
21	УРСГАЛ ЗАРДАЛ	994,442,921.94	1,275,202,793.46
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	994,442,921.94	1,257,554,093.46
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	570,544,445.21	785,621,238.66
210101	Үндсэн цалин	393,511,678.21	492,545,015.15
210102	Нэмэгдэл	160,405,286.00	275,140,873.51
210104	Урамшуулал	16,627,481.00	17,935,350.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	72,683,824.00	98,963,984.80
210201	Тэтгэврийн даатгал	48,728,498.00	68,068,844.35
210202	Тэтгэмжийн даатгал	6,253,981.00	8,024,451.78
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,999,765.00	3,942,925.89
210204	Ажилгүйдлийн даатгал	1,252,333.00	3,941,231.89
210205	Эрүүл мэндийн даатгал	12,449,247.00	14,986,530.89
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	243,270,900.00	239,376,800.00
210301	Гэрэл, цахилгаан	10,419,715.80	10,228,212.42
210302	Түлш, халаалт	221,258,328.20	218,667,611.58
210303	Цэвэр, бохир ус	11,592,856.00	10,480,976.00
2105	Нормативт зардал	75,539,130.00	91,595,250.00
210502	Хоол, хүнс	75,539,130.00	91,595,250.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,970,500.00	3,470,000.00
210604	Урсгал засвар	5,970,500.00	3,470,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,418,600.00	2,797,400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,418,600.00	2,797,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	25,015,522.73	35,729,420.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	20,759,722.73	26,905,120.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,255,800.00	8,824,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		17,648,700.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		17,648,700.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		17,648,700.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	124,214,278.06	76,406.54
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)		
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	5,000,000.00	1,109,800.00
	Дотоод эх үүсвэрээр	5,000,000.00	1,109,800.00
223001	Бусад хөрөнгө	5,000,000.00	1,109,800.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(5,000,000.00)	(1,109,800.00)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	119,214,278.06	(1,033,393.46)
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		137,769,101.06
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		136,735,707.60

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	533,912,670.00	433,299,310.33	(549,777,174.32)	417,434,806.01
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
5	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
7	Тайлант үеийн үр дүн			118,512,862.42	118,512,862.42
8	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	533,912,670.00	433,299,310.33	(431,264,311.90)	535,947,668.43
9	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
10	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
11	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
12	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
13	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
14	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				
15	Тайлант үеийн үр дүн			(3,035,812.40)	(3,035,812.40)
16	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	533,912,670.00	433,299,310.33	(434,300,124.30)	532,911,856.03

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэлийн зөрүү/хэтрэлт, хэмнэлт/	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,413,048,200.00	1,276,312,593.46	136,735,606.54	90.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,413,048,200.00	1,276,312,593.46	136,735,606.54	90.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,395,399,500.00	1,258,663,893.46	136,735,606.54	90.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	890,049,200.00	785,621,238.66	104,427,961.34	88.3
210101	Үндсэн цалин	572,912,800.00	492,545,015.15	80,367,784.85	86.0
210102	Нэмэгдэл	296,459,200.00	275,140,873.51	21,318,326.49	92.8
210104	Урамшуулал	20,677,200.00	17,935,350.00	2,741,850.00	86.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	105,581,200.00	98,963,984.80	6,617,215.20	93.7
210201	Тэтгэврийн даатгал	71,796,700.00	68,068,844.35	3,727,855.65	94.8
210202	Тэтгэмжийн даатгал	8,445,000.00	8,024,451.78	420,548.22	95.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,223,200.00	3,942,925.89	280,274.11	93.4
210204	Ажилгүйдлийн даатгал	4,223,200.00	3,941,231.89	281,968.11	93.3
210205	Эрүүл мэндийн даатгал	16,893,100.00	14,986,530.89	1,906,569.11	88.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	239,376,800.00	239,376,800.00	-	100.0
210301	Гэрэл, цахилгаан	12,159,100.00	10,228,212.42	1,930,887.58	84.1
210302	Түлш, халаалт	214,071,900.00	218,667,611.58	(4,595,711.58)	102.2
210303	Цэвэр, бохир ус	13,145,800.00	10,480,976.00	2,664,824.00	79.7
2105	Нормативт зардал	113,795,100.00	91,595,250.00	22,199,850.00	80.5
210502	Хоол, хүнс	113,795,100.00	91,595,250.00	22,199,850.00	80.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,470,000.00	3,470,000.00	-	100.0
210604	Урсгал засвар	3,470,000.00	3,470,000.00	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,797,400.00	2,797,400.00	-	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,797,400.00	2,797,400.00	-	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	40,329,800.00	36,839,220.00	3,490,580.00	91.2
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	31,505,400.00	28,014,920.00	3,490,480.00	88.7
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,824,400.00	8,824,300.00	100.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	17,648,700.00	17,648,700.00	-	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	17,648,700.00	17,648,700.00	-	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	17,648,700.00	17,648,700.00	-	100.0
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,413,048,200.00	1,275,279,200.00	137,769,000.00	90.3
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,032,397,400.00	1,032,397,400.00	-	100.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,032,397,400.00	1,032,397,400.00	-	100.0
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	242,846,800.00	242,846,800.00	-	100.0
132001	Орон нутгийн төсвөөс	242,846,800.00	242,846,800.00	-	100.0
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	137,804,000.00	35,000.00	137,769,000.00	0.0
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	35,000.00	35,000.00	-	33.3
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	137,769,000.00		137,769,000.00	
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		137,769,101.06	(137,769,101.06)	
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		136,735,707.60	(136,735,707.60)	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Сайхан сумын гуравдугаар цэцэрлэг нь “Хамтын оролцоо, үнэлгээний үр дүнд суурилсан менежментийг сайжруулж, хүүхэд бүрийн онцлогт нийцүүлэн сурах, хөгжих арга барилыг нэвтрүүлэн сургалтын үйл ажиллагааг чанар, үр дүнтэй зохион байгуулах” гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан байна.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Боловсролын ерөнхий хууль, сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийг багш, ажилтан, эцэг эх, асран хамгаалагч, иргэдэд сурталчилан таниулах, тэдний оролцоотой хэрэгжүүлэх
- Малчин болон алслагдсан бүс нутагт амьдарч байгаа өрхийн хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийг хувилбарт сургалт үйл ажиллагаагаар дэмжих, 5 настай хүүхэд бүрийг сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамруулах, сургуульд элсэн суралцуулах бэлтгэл хангах
- Цэцэрлэгийн хамран сургах тойргийн 2-5 настай хүүхдийг боловсролд хамрагдах хүртээмжтэй тэгш боломж олгон эцэг эх,асран хамгаалагч, багш нарын хамтын хариуцлагыг нэмэгдлүүлэх
- Цэцэрлэгийн орчимд хүүхдийн аюулгүй байдлыг хамгаалах, сурах, хөгжих, төлөвших үйл явцыг дэмжих тусгайлсан арга хэмжээг багш, ажилтан, эцэг эх, асран хамгаалагч, олон нийтийн оролцоо, түншлэлд тулгуурлан хэрэгжүүлэх
- Онцгой байдлын үед хүүхэд өөрийгөө болон бусдыг хамгаалах, мэдлэг, ур чадвараа хэрэгжүүлэх дадлага сургуулалтыг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулж аливаа гамшигийн эрсдэлийг даван туулах чадварыг хөгжүүлэх

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой;*
- *Засгийн газрын 2024 оны 01 сарын 25-ны өдрийн 39 дүгээр тогтоолоор “Хувьсах зардал болон гүйцэтгэл, үр дүнд суурилан санхүүжүүлэх журам”;*
- *Засгийн газрын 2024 оны 01 сарын 17-ны өдрийн 25 дугаар тогтоолоор “Боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааны болон багшийн ажлын гүйцэтгэл, чанар, үнэлгээний үр дүнд үндэслэн олгох нэмэлт урамшууллыг санхүүжүүлэх журам”;*
- *Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ний өдрийн 128 дугаар тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон;*
Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28–ний өдрийн 84 дүгээр тогтоолоор хөдөө орон нутгийн нэмэгдэл шинэчлэгдсэн гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд тус цэцэрлэгийн санхүүгийн үйл ажиллагаанд Боловсролын ерөнхий газрын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас хяналт, шалгалт хийгдээгүй боловч сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сайхан сумын гуравдугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

Сайхан сумын гуравдугаар цэцэрлэг нь Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан Боловсрол, Шинжлэх Ухааны салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсөвт байгууллагуудад мөрдөгдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сайхан сумын гуравдугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 9,861.0 мянган төгрөгөөр буюу 2.0 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	137,769.1	136,735.7	(1,033.4)
Авлага	-	-	-
Бараа материал	63,574.0	85,836.9	22,262.9
Үндсэн хөрөнгө	349,584.4	318,493.9	(31,090.5)
Нийт хөрөнгө	550,927.5	541,066.5	(9,861.0)
Өр төлбөр	14,979.8	8,154.7	(6,825.1)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	535,947.7	532,911.8	(3,035.9)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	550,927.5	541,066.5	(9,861.0)

Дээрх хүснэгтээс харахад дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 136,735.7 мянган төгрөг болж 1,033.4 мянган төгрөгөөр буурсан нь мөнгөн хөрөнгийн зарцуулалттай холбоотой;
- Бараа материалын дансны үлдэгдэл 85,836.9 мянган төгрөг болж 22,262.9 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 124,151.1 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, аймгийн Боловсролын газраас 17,600.0 мянган төгрөгийн хүүхдийн тоглоом, цэцэрлэгийн хүүхдийн эцэг эхээс 22,238.4 мянган төгрөгийн хүүхдийн тоглоом, хичээлийн хэрэгсэл, ахуйн хэрэгсэл үнэ төлбөргүй орлогоор бүртгэж авсан бөгөөд үйл ажиллагаанд 141,726.6 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулснаас,
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 318,493.9 мянган төгрөг болж 31,090.5 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 1,109.9 мянган төгрөгийн сандал, принтер, аймгийн Боловсролын газраас 1,500.0 мянган төгрөгийн зөөврийн компьютер, эцэг эх, ажилчдын хандиваар 8,852.8 мянган төгрөгийн зурагт тус тус үнэ төлбөргүй авч, тайлант онд 42,553.2 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцсоноос шалтгаалсан байна.
- Өр төлбөр дансны үлдэгдэл 8,154.7 мянган төгрөг болж 6,825.1 мянган төгрөгөөр буурсан нь 2023 онд үүссэн түлш халаалтын өр төлбөрийг төлснөөс шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 826,691.0 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 185,857.3

мянган төгрөг нийт 1,012,548.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснээс улсын төсвийн санхүүжилтийг 343,510.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 1,170,201.4 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвийн санхүүжилтийг 56,989.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 242,846.8 мянган төгрөгөөр, нийт 1,413,048.2 мянган төгрөгөөр баталсан байна.

Тайлант 2024 онд 7 удаа төсвийн зохицуулалт хийгдэж, улсын төсвөөс 1,032,397.3 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 242,846.8 мянган төгрөгийн санхүүжилт, туслах үйл ажиллагааны орлогоос 35.0 мянган төгрөгийн, урьд оны үлдэгдлээс 137,769.1 мянган төгрөг зарцуулахаар зэрэг төсвийг нийт **1,413,048.2** мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна. Үүнд:

- Цалин, НДШ-ийн зардлыг 268,470.4 мянган төгрөгөөр,
- Тогтмол зардлыг 56,989.5 мянган төгрөгөөр,
- Хоолны зардлыг 38,700.7 мянган төгрөгөөр,
- Урсгал зардлыг 17,648.7 мянган төгрөгөөр,
- Мэдээлэл технологийн үйлчилгээний зардлыг 2,797.4 мянган төгрөгөөр,
- Бараа үйлчилгээний бусад зардлыг 15,893.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр төлөвлөсний дагуу нийт 1,413,048.2 мянган төгрөгийн орлого бүрдүүлснээс, урсгал үйл ажиллагаанд 1,276,312.6 мянган төгрөгийг зарцуулж, 136,735.7 мянган төгрөгийг үлдэгдлээр тайлагнасан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,276,312.6 мянган төгрөг буюу 90.3 хувьтай байгаа нь хоолны зардлыг 22,199.9 мянган төгрөгөөр, боловсролын стандарт сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлыг 113,167.8 мянган төгрөгөөр, тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Хөтөлбөр, арга хэмжээ	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт /хувиар/
Улсын төсвөөс санхүүжих	1,170,201.4	1,033,465.8	136,735.7	88.3
80233 - Хүүхэд хамгаалал	1,207.3	1,207.3	0.0	100.0
81605 - Эрүүл мэндийг дэмжих	2,036.4	2,035.0	1.4	99.9
81807 - Цэцэрлэгийн хүүхдийн хоол	113,795.2	91,595.3	22,199.9	80.5
81816 - Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	3,291.4	3,291.4	0.0	100.0
81823 - Боловсролын байгууллагын багш, ажиллагсдын мэргэжил дээшлүүлэх	2,036.4	670.0	1,366.4	32.9
81834 - Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх	1,005,323.2	892,155.4	113,167.8	88.7
81835 - Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	42,406.6	42,406.4	0.2	100.0
81844 - Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн сургалтын орчинг сайжруулах	105.0	105.0	0.0	100.0
Орон нутгийн төсвөөс санхүүжих	242,846.8	242,846.8	0.0	100.0
80111 - Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	242,846.8	242,846.8	0.0	100.0

ДҮН	1,413,048.2	1,276,312.6	136,735.7	90.3
-----	-------------	-------------	-----------	------

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сангийн яамны 2022 оны 02 дугаар сарын 28-ны “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгээр байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансыг хаасан байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Сайхан сумын гуравдугаар цэцэрлэг хүнсний худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАҮХАТ хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад байршуулж, зохион байгуулсан байна. Үүнд:

№	Тухайн жилд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний нэр төрөл, тоо, хэмжээ, хүчин чадал	Батлагдсан төсөв	Гэрээний дүн	Тендер шалгаруулалтын арга
1	Цэцэрлэгийн хүүхдийн хоол	75,094.4	75,094.4	ХТШ
	Нийт дүн	75,094.4	75,094.4	

Бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендер шалгаруулалтыг харьцуулалтын аргаар /Анхны батлагдсан төсвөөр тендерийн үнийн саналыг өгсөн/ гүйцэтгэж “Ханангийн хөх бууц” ХХК -тай гэрээ байгуулж худалдан авалтыг гүйцэтгэсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сайхан сумын гуравдугаар цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн эцэг эхчүүдээс хүүхдийн сургалт, эрүүл ахуйн хэрэгцээнд үнэ төлбөргүй өгсөн хөрөнгийг орлогоор бүртгэж зарцуулалтад хяналт тавих зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “Мэдээлэл аудит” ХХК-ийн шинжээч З.Азжаргал гүйцэтгэж, чанарын хяналтыг салбарын захирал А.Гэрэлмаа, анхан шатны хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Б.Батмөнх, хоёр дахь шатны хяналтыг дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сайхан сумын гуравдугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Мэдээлэл аудит ХХК-д 2025 оны 01 дүгээр сарын 23-ний өдрийн 01 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн шатны материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,026,264.5 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 15,393.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Сайхан сумын гуравдугаар цэцэрлэг нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Бичгийн цаас, принтерийн хорны зардлыг хэмнэх зорилгоор бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтөд дотоод сүлжээг ашигласан,
- Шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр авч нөөцлөөгүй,
- Хэвлэл захиалгын төлбөр гаргалгүй ажилласан зэрэг төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх

зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансанд мэдээлбэл зохих 29 төрлийн 171 мэдээллийг бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант онд бусад хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хамаарах алдаа, зөрчил илрээгүй.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

“Мэдээлэл аудит” ХХК-ийн 2024 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 24/57 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 754.8 мянган төгрөгийн төсөвт тусгагдаагүй зардал гаргаж ур чадварын цалин хөлсийг илүү олгосон зөрчилд 1 төлбөрийн акт, газрын гэрчилгээг шинэчлэн бүртгээгүй 1 зөвлөмж өгөгдсөн байна.

Өмнөх оны аудитаар өгөгдсөн төлбөрийн акт, зөвлөмжийн биелэлтийг нотлох баримттай тулган баталгаажуулахад 50 хувийн биелэлттэй байна. Газрын гэрчилгээг шинэчлэн бүртгүүлэх 1 зөвлөмж хэрэгжээгүй бөгөөд тухайн цэцэрлэгийн газар нь Орхон сумын нутаг дэвсгэрт харъяалалтай боловч Сайхан сумын Засаг даргын захирамжаар олгогдсон, 2 сумын хилийн цэсийн маргаантай холбоотойгоор шийдэгдээгүй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	754.8	1	754.8	100.0
Албан шаардлага					
Зөвлөмж	1	-		-	-
Нийт дүн	2	754.8	1	754.8	50.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа илрээгүй болно.

Аудитаар нийт **18,924.4** мянган төгрөгийн 2 зөрчил¹ илэрч 1 зөрчилд төлбөрийн акт тогтоон, 1 зөрчилд зөвлөмж хүргүүлээ.

5.1 Төлбөрийн акт

1. Сахилгын шийтгэлтэй гал тогооны туслах ажилтан Г.Цэцэгбаярт сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаа болоогүй байхад үр дүнгийн урамшуулал 486.0 мянган төгрөгийг олгосон байна. Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.8 дахь “Хөдөлмөрийн сахилгын шийтгэл ногдуулснаас хойш нэг жил өнгөрвөл сахилгын шийтгэлгүйд тооцно”, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын хавсралтын 4.3 дахь “Улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг сургалтын байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, албан тушаалын тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээнд заасан ажил үүргээ гүйцэтгэсэн, ажлын байранд хөдөлмөрийн сахилга, ёс зүйн зөрчил гаргаагүй багш, туслах багш, бусад албан хаагчид олгоно” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон үр дүнгийн урамшууллыг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Анхан шатны баримт хөтлөлт, бүрдүүлэлттэй холбоотой асуудал:

1.1 Илрүүлэлт: Эцэг эхчүүдээс хүүхдийн сургалт, эрүүл ахуйн хэрэгцээнд үнэ төлбөргүй өгсөн 18,438.4 мянган төгрөгийн бараа материалыг орлогоор бүртгэж нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4. Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.1-д “аж ахуйн бүх ажил, гүйлгээ”, 14.4.5-д “бүх орлого” гэсэн заалтыг зөрчсөн байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Үнэ төлбөргүй хүлээн авсан орлогыг бүртгэлд бүрэн тусгаж, зарцуулалтад хяналт тавьж ажиллах

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5 дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15 -ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс				Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
							Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Сахилгын шийтгэлтэй ажилтанд үр дүнгийн урамшуулал бодож олгосон	1	486.0	1	486.0								
Үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийг бүртгэлд тусгаагүй	1	18,438.4					1	18,438.4				
Дүн	2	18,924.4	1	486.0			1	18,438.4				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								